



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№130 /344/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.07.27

Цаг үе, үйл явдал

## ШИЛЖИН ЯВАХ ТУГИЙГ ГАРДУУЛАВ



тугийг гардуулан өглөө.

Энэхүү тугийг ЗХ-ний анги, байгууллага тус бүр гурван хоног аялуулах бөгөөд энэ хүрээнд эрүүл иргэн үндэсний баялаг, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж хурдаа тохируулж, анхаарал болгоомжтой аялахыг уриалахын зэрэгцээ олон талт арга хэмжээг зохион байгуулах юм.

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанд туг дамжуулсан БЗД-ийн Цэргийн штабын хувьд "Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар" цахим хуудсанд замын хөдөлгөөний аюулаас урьдчилан сэргийлэх дүрс бичлэг болон зурагт хуудаснуудыг байршуулах, Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зурагт хуудсыг хэвлэж байгууллага иргэдэд ихээр үйлчилдэг газарт байршуулах, БЗД-ийн Засаг даргын Тамгын газрын үүдний лед дэлгэцээр богино хэмжээний дүрс бичлэгийг гаргаж иргэдэд түгээх, дүүргийн 43 хороодын засаг дарга, зохион байгуулагч нарт зурагт хуудаснуудыг тараан хороодын байруудад хэвлэн байршуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлжээ.

Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" аяны хүрээнд зам тээврийн ослоос иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцогчдын буруу дадлыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж тус аяны зорилгыг сурталчлан таниулах ажил хэрэгжиж байгаа. Уг ажлын хүрээнд БЗД-ийн

Иргэдийн ИТХ, ЗДТГ-ын Цэргийн штаб, Цагдаагийн газраас дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын дунд "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" аяны тугийг аялуулж байгаа бөгөөд өчигдөр БЗД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дайчилгааны офицер дэд хурандаа Ш.Бат-Өлзий Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны дарга хурандаа Л.Баярцогтод аяны



## НУБ-ЫН "ЦЭРГИЙН АЖИГЛАГЧ ОФИЦЕР"-ЫН ДАМЖАА ХИЧЭЭЛЛЭЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны Сургалтын нэгдсэн төвд Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цэргийн ажиглагч офицер"-ын дамжаа хичээллэж байна. Энэ сарын 18-ны өдөр эхэлсэн тус дамжаа 8 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд үргэлжлэх юм. Манай оронд 14 дэх удаагаа зохион байгуулагдаж буй энэ удаагийн дамжааг АНУ-ын Энхийг дэмжих санаачилгын хөтөлбөр "GPOI"-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Зэвсэгт хүчин бие даан явуулж буйгаараа онцлог юм.

Дамжаанд Зэвсэгт хүчний анги, байгууллагаас 15, цагдаагийн байгууллагаас 1, Индонез, Вьетнам, Балба, Филиппин зэрэг орноос 6 офицер суралцаж байгаа бөгөөд Зэвсэгт хүчнээс 12, "Дэлхийн энхийг санаачлах хөтөлбөр"-ийн 1 чиглүүлэгч багш хичээл зааж байна. Эдгээрийн 2 нь эмэгтэй сургагч багш, 4 эмэгтэй цэргийн алба хаагч /суралцагч/ байгаа нь энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй цэргийн алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын нэг хэлбэр юм.

Дамжаа онол, дадлага хосолсон хэлбэрээр 3 үе шаттайгаар явагдах ба сүүлийн шатанд буюу хээрийн дадлага ажиллагааны хүрээнд анх удаа агаарын эргүүл, усан эргүүлийг бодитоор зохион байгуулахаар бэлтгэлийг базаан ажиллаж байна. Монгол Улс тэр тусмаа Зэвсэгт хүчнийг гадаадын улс орнуудад сурталчлах, дадлага туршлага хуримтлуулах өндөр /үргэлжлэл нь арын нүүрт/

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ 07


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 23

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.183.00	3.190.0
EUR 🇪🇺	3.242.0	3.260.0
CNY 🇨🇳	472.50	474.00
RUB 🇷🇺	50.80	51.50
JPY 🇯🇵	23.00	23.20
KRW 🇰🇷	2.39	2.41

## ЗУРХАЙ



2022.07.27 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 29

**ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Эрлэг лугаа учирна

Наран ургаа, шингэх:

05.23-20.34

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал: Мод

Энэ өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрэхэд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсад хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 577,340,054

Эдгэрсэн

Нийт: 547,126,909

Нас барсан

Нийт: 6,407,601

Цахим шууданд

# НҮБ-ЫН “ЦЭРГИЙН АЖИГЛАГЧ ОФИЦЕР”-ЫН ДАМЖАА ХИЧЭЭЛЛЭЖ БАЙНА

/түрүүч нь I нүүрт/ ач холбогдолтой энэ дамжааг эх орондоо бие даан явуулахын тулд олон улсын сургалтын төвүүдийн жишигт нийцүүлэн, тодорхой шаардлагуудыг хангаж, цаашид энэ төрлийн сургалтыг явуулах зөвшөөрөл буюу НҮБ-ын батламж авахаар зорьж буй юм. Тиймээс НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын Нэгдсэн сургалтын албаны Цэргийн сургалт хариуцсан офицер хурандаа Александр Кавалканти Симон хүрэлцэн ирж энэ удаагийн сургалт дамжааг шалгах үнэлэхээр ажиллаж байна.



## БИ ТЭНГЭРЛЭГ ААВЫНХАА ТӨГСӨШГҮЙ ҮРГЭЛЖЛЭЛ



“Би сарвайснаа авдаг бэлтэй аавын хүү биш ч Санасандаа хүрэх зорилготой аавын хүү Би аавынхаа үргэлжлэл С а й х а н инээмсэглэлийнх нь үргэлжлэл Гунигаа нууж алхдаг тэвчээрийнх нь үргэлжлэл Би тэнгэрлэг аавынхаа төгсөшгүй үргэлжлэл” хэмээн шүлэглээд Та минь эрүүл энх, урт наслаарай ааваа хүү нь тандаа хайртай, төрсөн өдрийн баярын мэнд хүргэе хэмээн видео мэндчилгээг хүргүүлсэн юм. Видеог Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн соёл хүмүүжлийн офицер хошууч Ө.Нарантуяа хүргэж өгч тэдний гэр бүлийн баяр дээр нь баяр нэмлээ. Эр цэргийн албанд үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ ирээдүйнхээ төлөө, өмнөө тавсан зорилгоо биелүүлж буй хүүгээсээ ийм гэнэтийн бэлэг Н.Гантөр энэ үеэр Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн удирдлага, хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөлөө.

**Зэвсэгт хүчний 120 дугаар анги** Монгол Улсын баатар, хурандаа генерал Б.Цогийн нэрэмжит, Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн Танк эсэргүүцэх артиллерийн батареины байлдагч Г.Ганбаярыг энд онцолж байна. Байлдагч Г.Ганбаяр нь цэргийн эрдэмд шамдан суралцахын зэрэгцээ энэ оны 2 дугаар сард цахимаар хичээл сургалтад хамрагдаж, шалгалтаа өгөн Техник технологийн политехникийг “Гагнуурчин” мэргэжлээр амжилттай суралцаж, төгссөн тэргүүний дайчдын нэг юм. Тэрээр энэ сарын 25-ны өдөр өөрийн

аав Н.Гантөрийнхөө төрсөн өдрөөр гэнэтийн бэлэг барьж баярлууллаа.



**Хошууч Ө.НАРАНТУЯА**

# КОМАНДЛАЛЫНХАН ЭРГЭН ТОЙРНОО ЦЭЦЭГЖҮҮЛЖ, НОГООН БАЙГУУЛАМЖАА НЭМЭГДҮҮЛЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийхэн тэргүүлэх үүрэгтэйгээр оролцож байгаа билээ. Монгол Улсын газар нутгийн дийлэнхэд тархаад байгаа цөлжилтийг бууруулах, ойжуулах, байгаль орчныг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэхээр Зэвсэгт хүчнийхэн 2030 он гэхэд 27 сая мод тарьж, ургуулан ногоон орчныг бий болгох зорилт тавин ажиллаж байна. Цөлжилтийг бууруулах санаачилгаас гадна Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын ногоон

байгууламжийг нэмэгдүүлэх, сэргээн сайжруулах, цэцэгжүүлэх, мод, бут, зүлэг тарих ажлыг цэргийнхэн эрчимтэй эхлүүлж, ажил хэрэг болгосоор байгаа юм. Үүний нэгэн жишээ нь Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал бөгөөд энэ он гарсаар өөрийн байрлалдаа 2000 гаруй хайлаас, шар хуайсыг үржүүлж, 5 төрлийн 2000 гаруй цэцгийн мандлаар байгууллагынхаа өнгө үзэмжийг нэмэгдүүлэв. Цэцэгжүүлэх ажлыг Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Мод үржүүлгийнхэнтэй хамтран гүйцэтгэсэн бөгөөд өдөр бүрийн арчилгаа,

тордолгоог тус командлалын Хангалт тасгийн талбайн үйлчилгээний үйлчилгээний тасгийн талбайн үйлчилгээ хариуцсан ажилтан Л.Пүрэвбаяр гүйцэтгэж байна. Л.Пүрэвбаяр нь ойжуулах, цэцэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд олон чиглэлээр тэргүүлэх үүрэгтэй оролцдог ажилтан албан хаагчдын нэг юм. Үүний зэрэгцээ Хуурай замын нэгтгэл, ангиуд бие бүрэлдэхүүнээ эрүүл, аюулгүй орчинд ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж, ангийн байрлалыг ногоон хотхон болгохоор ажиллаж байна.



## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН 20 ЖИЛИЙН ОЙГ УГТСАН АЖЛУУД

**ЗХНЛ** Зэвсэгт хүчний Нэгдсэн Лаборатори байгуулагдсаны 20 жилийн ой ирэх сарын 2-ны өдөр тохиож буй юм. Ойг угтаж олон төрлийн

бүтээлч ажлуудыг өрнүүлж байгаагийн нэг нь хурлын танхимын засварын ажил юм. Тус ажлыг ахмад Я.Цогнэмэх, Б.Төгөлдөр, Б.Мөнхмарт, Ц.Занабазар,

Ч.Гурдаш нар хариуцан заалны шал, тааз, хана гэрэлтүүлгийг шинээр суурилуулан ойн өмнө бэлэн болгохоор ажиллаж байна.

